



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/АЗН

Булган сум

**“Чадварлаг төрийн албан хаагч, хариуцлагатай
төрийн алба” сарын аяныг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Чадварлаг төрийн албан хаагч, хариуцлагатай төрийн алба” сарын аяны хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах зардал 19,700,000 (арван есөн сая долоон зуун мянга) төгрөгийг Аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн харилцах данс дахь “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын дэмжлэгээс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.


3. Төрийн албан хаагчийн сарын аяны хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээг сум, байгууллагын хэмжээнд нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг сум, байгууллагын дарга нарт, аяны хүрээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээний тайланг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор нэгтгэн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025. оны
11 дүгээр сарын 25-ны/ний өдрийн
А.132Н дугаар захирамжийн хавсралт



**“ЧАДВАРЛАГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ХАРИУЦЛАГАТАЙ
ТӨРИЙН АЛБА” САРЫН АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ**

д/д	Зохион байгуулах ажил	Нэгж үнэ	Нийт шаардагдах хөрөнгө
1	2	3	4
1	Төрийн албан хаагчдын талархлын долоо хоног, байгууллага хамт олноороо бүтээлч, шинэлэг ажил арга хэмжээг зохион байгуулах	1-р байр - 1000 000 төгрөг 2-р байр - 800 000 төгрөг 3-р байр - 600 000 төгрөг Өргөмжлөл -150 000 төгрөг	2550,000
2	Төрийн албан хаагчдад зориулсан соён гэгээрүүлэх сургалт, мэдээлэл, лекц	Лектор -2 *1500	3000,000
3	“Чадварлаг төрийн албан хаагч, хариуцлагатай төрийн алба” илтгэлийн уралдаан 2 үе шаттай	1-р байр - 500 000 төгрөг 2-р байр - 400 000 төгрөг 3-р байр - 300 000 төгрөг Өргөмжлөл -150 000 төгрөг	1,350,000
4	“Алтан хонх” хөгжөөнт танин мэдэхүйн тэмцээн (Төрийн ажилтан, албан хаагчид хамрагдана)	1-р байр - 500 000 төгрөг 2-р байр - 400 000 төгрөг 3-р байр - 300 000 төгрөг Өргөмжлөл -150 000 төгрөг	1,350,000
5	Волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээн	Волейбол: 1 байр 2*800.000=1600,000 2 байр 2*600.000=1200,000 3 байр 2*400.000=800,000 Шилдгүүд 1000,000 Шүүгч -300,000 Өргөмжлөл 6ш*60/450,000 Медаль- 48*12000/700,000 Заалны түрээс-400,000	6,450,000
5	Байр, хоолны зардал		5,000,000
Нийт-19,700,000			